

ЭХ ХЭЛ – ХЭРЭГЛЭЭ

Б.Бадамсүрэн

40-р сургууль

2004-2005 оны хичээлийн жил нь ЕБС-ийг сургалт 11 жилийн тогтолцоонд шилжих бэлтгэлийг бүрэн хангах, улмаар шинэчилсэн стандартыг хэрэгжүүлж эхэлж байгаагаараа онцлог билээ. ЕБС-ийн багш бид бага, дунд боловсролын шинэ стандартыг өмнөх хичээлийн жилээс эхлэн уншиж, судалж байна. Яг одоогийн байдлаар шинэ стандартын тухайд сайн мэдээд байгаа зүйл ч бага, бас огт мэдэхгүй ч юм үгүй, ямар ч байсан анхан шатны ойлголттой боллоо. Монгол хэлний хичээлийн сургалтад:

1. Монгол хэлний хичээлийн хөтөлбөр 1998 он (5-10 кирилл, 5-8 монгол бичиг)

2. Монгол хэлний хичээлийн стандартыг хэрэгжүүлэх зөвлөмж 1998 он (1-10-р анги)

3. Дунд сургуулийн уран зохиолын хөтөлбөр 1993 он(5-10-р анги)

4. Монгол хэл, уран зохиолын сургалтын технологи шинэчлэлийн асуудал 2002 он зэрэг стандарт хөтөлбөр, зөвлөмжийг хэрэглэж байна.

Мөн 11 жилийн тогтолцоонд шилжих туршилтад зориулсан монгол хэл, уран зохиолын боловсролын стандартыг 2003 - 2004 оны хичээлийн жилд монгол хэлний багш нар уншиж, танилцаад байна. Ер нь улс, хот, дүүрэг сургуулийн хэмжээнд монгол хэлний сургалт сайн байна гэж хэзээ ч хэлэгдэж дүгнэгдэж байгаагүй. Хааяа нэг арай гайгүй байгаа сургууль л байдаг байх. Гэсэн хэдий ч 1-10 дугаар ангид жил бүр монгол хэлний хичээлээр улсын болон анги дэвших шалгалт авдаг.

Шалгалтын явцаас харахад 4, 8, 10 дугаар ангийн монгол хэлний хичээлийн шалгалт их өндөр үнэлгээтэй гардаг. Харин 5, 6, 7, 9 дугаар ангиудаас “F” үнэлгээтэй сурагч олон гарч, хэд хоногийн дараа дахин шалгалт нэртэй шалгалтыг өгч бүгд “D” үнэлгээ аваад л анги дэвшихнэ. 5, 6, 7 дугаар анги тус бүрээс шалгалтад унасан сурагчид нь 2 ангид бараг багтдаггүй. Гэхдээ анги дэвших шалгалтад унаж байгаа сурагчдын тоо сүүлийн жилүүдэд ихэссээр байгаа. Өмнө нь нэг ангиас 2-4 сурагч сул үнэлгээ авдаг байсан бол өнөөгийн байдлаар нэг ангиас дунджаар 5-12 сурагч “F” үнэлгээтэй шалгагдах нь ердийн үзэгдэл болсон. Иймэрхүү дүр зураг давтагдсаар, нэг л мэдэхэд ЕБС маань 11 жилийн тогтолцоонд орох болчихлоо.

Яагаад ингэж олон сурагч шалгалтад унаад байна вэ? Ерөөсөө монгол хэлний сургалтад яагаад ахиц гардаггүй юм бол? гэдэг асуулт зүй ёсоор тавигдах цаг нь болсон байх аа. Олон ургалч үзлийг уралдуулан байж, дундаас нь оновчтой хувилбар гаргаж авах нь мэдээж. Шинэ стандартыг батлагдчихаас нь өмнө саналаа нэмэрлэе гэж бодлоо. Зөвхөн нэг хүний санал, үзэл бодол биш ЕБС -д ажиллаж буй монгол хэл, уран зохиолын багш нарын санал гэдэг утгаар үүнийг бичлээ.

Үүнд:

1. Монгол хэл, уран зохиолын агуулга (заах зүйл) ихсээд байдаг гэтэл цаг нь цөөрөөд байдаг. Улсын хэмжээнд Гэгээрлийн сайдын 100, 179-р тушаалаар батлагдсан дараах сургалтын төлөвлөгөөг баримталж байна.

Анги	5				6				7				8				9				10			
Улирал	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4
Монгол хэл	3	3	3	3	2	2	2	3	4	3	4	3	2	2	1	2	1	1	1	1	1	1	1	1
Монгол бичиг	2	2	2	2	2	2	2	2	1	1	1	1	1	1	1	1								
Уран зохиол	2	1	2	2	2	2	2	1	1	2	2	1	1	2	2	1	2	2	2	1	2	2	2	2

Дээрх төлөвлөгөөнөөс харахад 7-р ангийн монгол хэлний хичээлийн цаг (1999-2000 оны хичээлийн жилээс) сүүлийн жилүүдэд 1-2 цагаар нэмэгдсэн ямар учраас 7-р ангийн монгол хэлний цаг нэмэгдээд байгаа нь ойлгомжгүй, өмнө нь олон жил 2 цагаар монгол хэл ордог байсан. 7-р ангид “Өгүүлбэр зүй”-н хичээл дагнаж ордог. Миний бодлоор бичиг үсгийн сайн боловсролтой болгоход өгүүлбэр зүйн хичээл ач холбогдол багатай. Ер нь 1, 2 дугаар ангиас өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, 3, 4-р ангиас өгүүлбэрийн гишүүд-гээд л... 7, 8-р ангид бүтэн 2 жил давхар, дан янз бүрийн зурлага зурсаар байгаад л хамаг цаг дуусдаг. Ийм хичээл 10-р ангийг дуустал үргэлжилнэ. Эцэст нь энэ хүүхэд олон гишүүнт өгүүлбэртэй холимог нийлмэл өгүүлбэрээр ярьж байна, бичиг үсгийн боловсрол маш сайн, энэ хүүхэд зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрээр ярьж байна, бичиг үсгийн боловсрол тааруу байна гэж дүгнэхгүй шүү дээ.

Ахлах ангид уламжлалаар сорилоор аль чаргаар нь шалгалт авахад сурагчдын хамгийн их алддаг сэдэв нь өгүүлбэр зүй. Тухайлбал зурлага хийж өгүүлбэрийн бүтцийг ч тодорхойлж чаддаггүй.

10-р ангийн улсын шалгалтын материалаас сурагчид ямар зүйлийг хамгийн их алдаж байна вэ? гээд дүгнэлт хийхэд ямар өгүүлбэр болохыг тодорхойл гэсэн сорилыг олонх нь буруу хийсэн байдаг. Ийнхүү 1-10-р ангид нь маш их цаг, цаас өрж заагаад л байдаг, эцсийн үр дүн гардаггүй. Энэ нь амьдралд хэрэглээ талаасаа ач холбогдол багатай байдаг юм шиг. Тэгээд ч МУИС, МУБИС-ийн багш нар өгүүлбэр зүй тэр тусмаа зурлагын талаар зөрөөтэй байдаг. Ийм хүнээ хөгжүүлж бичиг үсгийн сайн боловсролтой хүнийг бэлтгэхэд ач холбогдол бага байгаа сэдвийн цагийг багасгаж ач холбогдол өндөртэй сэдвүүдийг түлхүү оруулбал монгол хэлний сургалтын эцсийн үр дүнд сайнаар нөлөөлөх нь дамжиггүй.

Хамгийн сонирхолтой нь 9, 10-р ангид монгол хэлний хичээл 1 цаг, монгол бичигт цаг байхгүй. Өөрөөр хэлбэл 9,10-р ангид монгол бичиг огт ордоггүй гэсэн үг. Гэтэл ахлах ангид физик 5 цаг, хими 4 цаг ордог. Энэ нь шинжлэх ухаан болон сурган хүмүүжүүлэх ухааны ямар үндэслэлээр монгол хэл 1цаг, монгол бичгийг огт оруулаагүй юм бэ? гэж асуумаар байна. Хэрвээ математикийн гүнзгий анги бол монгол хэлний цагаас л хасагдана.

Жишээ нь: математикийн гүнзгий 5, 6-р ангид монгол бичиг 1 цаг, 9,10-р ангид уран зохиол 1 цаг орох жишээтэй. Гэтэл 8, 9,10 дугаар ангиудын монгол хэл, уран зохиолын хичээлийн агуулга маш их. Ганцхан баримт дурдъя.

Б.Ренчиний намтар уран бүтээл 3 цаг заахаар хөтөлбөрт тусгагдсан энэ 3 цагт

- Намтар уран бүтээл.
- “Ану хатан”, “Гүнж” өгүүллэгийн агуулга утга санаа.
- “Үүрийн туяа” хэмээх гурамсан романы агуулга, утга санаа, дүр, түүхэн ач холбогдол гэх мэт. Энэ том бүтээлүүдийг 1-2 цагт л заах жишээтэй.

Тэгээд ч хүн бүр химич, физикч, математикч болохгүй нь ойлгомжтой. Харин хүүхэд бүрд, хүн бүрд бичиг үсгийн сайн мэдлэг, боловсрол, чадвар, дадлага хэрэгтэй гэдэгтэй хэнбугай ч маргахгүй биз ээ. Үүнээс үүдээд бодохлоор монгол хэлний сургалтыг маш том толгойтой, нарийхан цүүцгэр хөлтэй, хөл нь толгойгоо, биеэ даахгүй данхайгаад л явж ядаж байгаа амьтантай л жишмээр.

Монгол бичиг 3-6 дугаар ангид 1-2 цаг, 7-8 дугаар ангид 1 цаг ордог. 3-8-р ангийн дээрх 1-2 цагт хүүхэд бүрийг шударга сайхан уншдаг, зөв сайхан бичиж сургах ямар ч боломжгүй нь одоогийн монгол бичгийн сургалт бодтойгоор харуулж байна.

- Улмаар ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын хичээлийн сургалтын хувьд бага цагт их зүйлийг заах гэж сургасан ч юм үгүй, сургаагүй ч юм үгүй “тарамдсан” ойлголттой хүнийг л бэлтгэж байна.
 - Иймээс эсвэл цагаа нэмэх, эсвэл заах зүйлийн агуулгаа багасгаж бичиг үсгийн сайн боловсролтой болгоход чиглэсэн сургалт явуулмаар байна.
2. ЕБС-ийн монгол хэлний сургалтын нэг амин сүнс нь зөв бичих, мэдлэг чадвар эзэмшүүлэх асуудал байсан билээ.

Гэтэл шинэчилсэн, өөрчилсөн гэх хөтөлбөрт “Үсгийн дүрэм” өөрөөр хэлбэл зөв бичүүлж сургахад чиглэсэн зөв бичих дүрмүүд нь маш бага, 1-4 дүгээр ангид анги бүрд тараагаад Хэсэглээд оруулчихсан. Тэгээд ч анги бүрд залгамж холбоогүйгээр үсгийн дүрмээ үздэг. 5 дугаар ангид зарим дүрмийг зөвхөн

сэргээх маягаар цөөн цаг үздэг. Тэгээд л 10-р анги төгсгөл зөв бичүүлж сургахад чиглэсэн ганц ч санаа, сэдэв байдаггүй. Ер нь л “Нөхөх”, “Олох, “Зохиох”, “Хураангуйлах”, “Дэлгэрүүлэх”, “Сонгох” мөн схем “Диаграмм” янз бүрийн загвараар дүүрсэн сурах бичиг гарын авлагууд л хэрэглэдэг. Ямар ч залгамж холбоогүй анги бүрд л өөр өөр бүлэг Сэдвүүд өмнөхөө мартаад “салан баавгайн үлгэр” мэт... .

Тэгээд ч зах зээлийн ороо бусгаа үед хамгийн их орхигдсон хэлмэгдсэн зөв бичгийн дүрмийг ЕБС-д заах хичээл гэж баттай хэлэх байна. Тэр ч байтугай сэтгүүлчид, сурвалжлагчдын зарим материал телевизийн дэлгэцнээ, сонин хэвлэлд нийтлэгдэж буй зүйл нь бага зэрэг хэтрүүлэхэд юуны тухай бичсэн нь ойлгогдохгүй шахам алдаатай бичих нь байж болох ерийн л үзэгдэл мэт болчихсон. Иймд ЕБС-д зөв сайхан бичүүлж, сургахад чиглэсэн сургалтыг анги бүрд “гинжин хэлхээ” маягаар, нэлээд баялаг баримт, материалтайгаар оруулж суралцагчдын зөв бичих чадварыг тэргүүн зэрэгт тавьж үнэлдэг, үнэлгээний журамтай болмоор санагддаг.

- 1993-1994 оны хичээлийн жилийн анги дэвших, төгсөх шалгалтаас эхлээд л зөв бичих чадварын үнэлгээ хасагдсан шүү дээ. Энэ нь миний бодлоор монгол хэлний сургалтын эмгэнэл болсон юм даа.

Харин 2002-2003 оны хичээлийн жилээс шалгалтын сэдэв дотор бага ч гэсэн зөв бичих чадварын үзүүлэлт орсон байсан. 2003-2004 оны хичээлийн жилийн анги дэвших, Төгсөх шалгалт сэдэвт суралцагчдын зөв бичих чадварыг үнэлэх үзүүлэлт, өөрөөр хэлбэл мартагдсан “цээж бичиг” 3, 4, 5, 6-р ангиуд шалгалтад хамгийн өндөр оноо авахаар орж ирсэнд монгол хэлний багш нар “зөв бичих”-д анхаарсан байна шүү, овоо ш дээ! хэмээн ярилцаж байсан даа.

3. Шинэ стандартын дагуу сурах бичгүүд хийгдэнэ. Иймд сурах бичигт багш нараа бага ч " гэсэн бодолцсон,баримт материал сайтай, материалын хэмжээ нь харьцангуй их, өөрөөр хэлбэл 1-2 дасгал ажиллуулахдаа багш сайн тайлбарласны дараа сурагчид 15-20 минутад ажиллахаар тооцвол зүгээр юм шиг.

Ихэнх сурах бичгийн дасгал дадлагын ажил нь маш бага, нөхөх, хариулах, зарим нь ч ач холбогдол багатай схем, диаграмм ч юм уу 4-5 дасгалыг 20-30 минутад ажилласан болоод л өнгөрөх жишээтэй. Багш бид гол зүйлээ тайлбарласны дараа бататгах ажил нь нэлээд далайцтай арвин баялаг материалтай байна гэж хэлэх санаа.

ЕБС-ийн монгол хэлний багш нар Монгол улсын гавьяат багш Ц.Өнөрбаян багшийн бдугаар ангийн монгол хэлний сурах бичгийг л их магтдаг шүү дээ. Энэ нь нэг зүйл Хэлээд л байна гэсэн үг.

Шинэ стандарт залгамж байдлыг нэлээд бодолцсон нь талархалтай болжээ. Харин хэт ерөнхий, яг ямар сэдвийг хэддүгээр ангид үзэх гээд байгаа нь тодорхойгүй юм шиг. Нэлээд багцалж бүлэглэж оруулбал зүгээр болов уу. Учир нь хэчнээн ерөнхий байна төдий чинээ хүртээмж тааруу байх болно. “Хүн болгон адилгүй, хүлэг болгон жороогүй” гэгчээр ерөнхий байсан ч нарийсгаад төлөвлөөд заачих нь олон ч аль ч учраа олохгүй өмнө хойно нь оруулаад ерөнхий чигээр нь ерөнхийлөөд байхыг үгүйсгэх аргагүй ээ.

Монгол хэлний нэр томъёог өөрчлөхийн тулд өөрчилмөөргүй байна. “Нэмэгдэхүүний байрыг сольсноор нийлбэр нь өөрчлөгддөггүй” гэдэг шиг. Бичиг үсгийн сайн боловсрол эзэмшихэд онцын ач холбогдолгүй зөвхөн эрдэм шинжилгээний ажилтан эсвэл зэрэг цол хамгаалах эрдэмтэд их, дээд сургуулийн оюутны хүрээнд мэдвэл зохих тийм нэр томъёонууд сүүлийн жилүүдэд ЕБС-ийн монгол хэлний сургалтад их орж ирж байгаа.

Жишээ нь: Онцолбор үг, өгүүлбэр, баймж үг, өгүүлбэр баймж утга, зэргэд, тэгш зэргэд,зүйлчилсэн, төсөөт, бүхэл зүйжсэн, утга зүйжсэн, ганцажсан хэлц зэргийг ач холбогдолгүй,цаг үрж, хий төөрөгдүүлсэн хэрэглээ багатай нэр томъёонууд гэж боддог.

Харин шинэ стандарт болон хөтөлбөр сурах бичигт зөв бичих зүй, үг зүй, утга зүй,найруулга зүй, эх судлал зэрэг сэдвийг анги бүрд залгамж холбоотойгоор бататгах,нотлох, тулгуур баримт сайтайгаар

оруулж өгвөл суралцагчдыг амьдрах арга ухаанд сургах мэдлэг чадвар дадлага эзэмшүүлж, улмаар эх хэлээ хэрэглээ болгож чаддаг болоход тусалж, хүнээ хөгжүүлэх суурь найдвартай тавигдах нь мэдээж.

Монгол хэл, уран зохиол, монгол бичгийн хичээлийн цагийн хувьд ЕБС-ийн багш нар өөр өөрийн бодолтой явдаг юм билээ. Бидний бодлоор монгол хэл, монгол бичиг, уран зохиолын шинэ стандартад 7 хоногт заах хичээлийн цагийн тухайд дараах саналыг оруулж байна.

Анги	5				6				7				8				9				10			
Улирал	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4
Монгол хэл	3	3	3	3	3	3	3	3	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
Монгол бичиг	3	3	3	3	3	3	3	3	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
Уран зохиол	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2

Нэгэнтээ батлагдан мөрдөгдөж буй цаг нь маш тогтвортой баймаар. Хэн нэгэн хүний үзлээр аль нэгэн хичээлийн “золиос” болж монгол хэл, монгол бичиг, уран зохиолын хичээлийн цагаас хасдагийг зогсоомоор. Шинэ стандарт нь хэрэглээ,сэдвийн залгамж холбоотой байх талыг илүү анхаарч, хүнээ хөгжүүлэх, бичиг үсгийн сайн боловсролтой болгоход чиглэсэн хуучин стандартаас давуу болсонд ЕБС-ийн монгол хэлний багш нар баяртай байгаа.

Гагцхүү монгол бичиг, уран зохиолын цагийг хасмааргүй байна. Хүүхдийг ойлгосноо товч тодорхой, дараалал сайтай ойлгомжтой ярьж, бичиж сургахад уран зохиолын хичээл маш их үүрэгтэй. Гэтэл сүүлийн жилүүдэд уран зохиолын хичээлийн цагаас хасаад байгаагийн учрыг ердөө ч ойлгохгүй юмаа. Бид ЕБС-д өөрсдөө суралцаж байсан үеэ эргээд бодоход уран зохиолын хичээлээр олон сайхан шүлэг цээжилж “эх” зохиол уншиж, товчилж, зүйр цэцэн үгс, сургаал, мэргэн үг, ардын үлгэр домог,... оньсого таавар... гээд л хэчнээн сайхан сайхан сэдвүүдийг үздэг байлаа даа. Дээрх сэдвүүд стандартад, сурах бичигт тусгагдсан боловч 7 хоногт ганцхан цаг орох үед зарим сэдвийг орхин, эсвэл аль алиныг нь заасан болоод өнгөрөх жишээтэй.

Монгол хэл, уран зохиол, монгол бичгийн хичээлтэй онцын холбогдолгүй боловч, ЕБС-ийн монгол хэл уран зохиолын багш бэлтгэхэд чиглэсэн нэг санал дэвшүүлье. Үүнд: багш бэлтгэдэг сургуулиуд “монгол хэл-англи хэл”, “уран зохиол-түүх”, “түүх-пионерын удирдагч”, “монгол хэл-герман хэл” гэх зэрэг ангийг шинээр нээж элсэлт аваад төгсгөөд байгаа. Ийм завсрын гэмээр ангид суралцсан оюутан нь ЕБС-д дадлагаар ирээд л аль аль ч үгүй нь мэдэгддэг. Тэгээд ч ЕБС-д багшлах ямар ч боломжгүй. Учир нь ЕБС-д монгол хэлний хичээл хэдэн цаг заагаад, англи хэл хэдэн цаг заах тийм зохион байгуулалт байдаггүй. Эсвэл англи хэлээ дагнан эсвэл монгол хэлээ дагнах шаардлагатай болно.

ЕБС -ийн монгол хэлний багш нар нь монгол хэл, монгол бичиг, уран зохиолын хичээлийг 5-10 дугаар ангид заах ёстой. Би монгол хэлний хичээл заана, монгол бичиг, уран зохиол заахгүй гэх эрх байхгүй. Иймд дээрх “эрлийз” ангийн талаар цаашид анхаармаар юм шиг...

ЕБС-д (1-10 дугаар анги бүрд) 7 хоногт нэг ангид маш олон цагийн хичээл ордог.Жишээ нь: 5 дугаар ангид 7 хоногт 27-30 цаг, 6 дугаар ангид 27-29 цаг, 7-р ангид29-32 цаг, 8-р ангид 30-32 цаг, 9-р анги 30-31 цаг, 10-р ангид 31-33 цаг зарим ангид өдөр бүр 6-7 цагийн хичээл орох жишээтэй. Энэ олон цагийн хичээлээс болоод хүүхэд бичиг үсгийн боловсрол болон ерөнхий боловсролыг сайн эзэмшдэггүй. Харин ч суралцагчдыг залхаасан. Сурсан ч юмгүй цаг өнгөрөөсөн байдалд оруулдаг нь сургалтын эцсийн үр дүнгээр мэдрэгддэг. Иймд 7 хоногт 1 ангид орох хичээлийн цагийг тодорхойлохдоо хэрэглээ талыг нь анхаармаар. Эсвэл хагас сайн өдрийг ажлын өдөр болгох, тэгвэл өдөр тутам давхацсан орох анги танхим ч олдохгүй шахам энд тэнд явж хичээллэдэг, өгөөж багатай үр дүнгүй эрээвэр хураавар олон цаг нь зохицогдох талтай.

Ер нь сургалтын эцсийн үр дүн нь сурагчдад ухаалаг, шударга, орчиндоо зөв зохицон амьдрах цогц чадвар эзэмшүүлэх зорилготой. Ялангуяа зах зээлийн өнөөгийн нөхцөлд сургалт нь суралцагчдад

амьдрах арга ухаан, сурч мэдсэнээ амьдралдаа хэрэглэж чаддаг, хэрэглээ талаас нь илүү анхаарсан байх ёстой гээд л яриад бичээд байгаа шүү дээ.

Нэгэн сургалт семинар дээр МУБИС-ийн ректор Б.Жадамбаа "багш нар минь танар сурагчдадаа учиргүй их юм заах гээд байхын хэрэг ч үгүй, бас их зүйл мэдүүлэх ч хэрэггүй. Гагцхүү өөр өөрийн мэргэжлээрээ хүүхэд бүрийг бичиг үсгийн боловсрол сайтай хүн болгочих" хэмээн зөвлөхөд багш нар нижигнэтэл алга ташиж, ёстой л оюунлаг хүний үг байна даа гэгцгээж байсныг тэмдэглэмээр...

Энэ нь бичиг үсгийн сайн боловсролтой хүнийг бэлтгэх нь сургалтын эцсийн зорилт байх ёстой гэсэн үг гэж бид ойлгож байгаа. Миний хувьд энэ бичээд, нэмэрлээд байгаа зүйл нь 21-р зуунд эх орноо авч явах иргэд маань ямар ч байсан төрөлх монгол хэлээ сайн эзэмшсэн, бичиг үсгийн боловсрол сайтай байвал бусад боловсролыг олж авах боломж бүрдэнэ, улмаар өөрийгөө болон эх орноо хөгжүүлэхэд хүн бүр хувь нэмрээ оруулж чадна гэсэн санаа юм шүү. Хэрвээ өөрөө сайн мэдэхгүй байж илүү дутуу “юм” бичсэн байвал уучлаарай.